



СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 78/
32-01

Сүхбаатар сум

Хариуцлага тооцох тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага (Улсын байцаагч)-ын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь аймгийн Засаг даргын 2025 оны 11 дугаар сарын 17-ны өдрийн ДА-2025/04/ҮА-ОНА дугаартай удирдамжийн дагуу Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ын 2024-2025 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар тус үйлдвэрийн газрын ерөнхий нягтлан бодогч өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, өмч хөрөнгийн тооллого хийгээгүй, төлбөр тооцоог хянаж баталгаажуулаагүйгээс өр төлбөр үүсгэсэн, борлуулсан барааний өртөг зардлыг буруу бүртгэж тайлагнасан, санхүүгийн анхан шатны баримтыг аргачлал зааврын дагуу хөтлөөгүй, баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаж албан тушаалын чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:", 20.2.3-д холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;, 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д "Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах", Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7 дугаар зүйлийн 7.5-д "Санхүүгийн хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил, түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн албан

4325607210

тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ.” гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан, нягтлан бодогч Б.Гандөл холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ-ын дарга Ц.Уртнасанд даалгав.
3. Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.
4. Энэхүү албан шаардлагыг эс зөвшөөрвөл Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-т заасны дагуу хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ

Т.ОДСҮРЭН

СЭЛЭНГЭ АЙМАГ
ЗӨВШӨӨРСӨН:

ТОГӨЛДӨР-ЕРӨӨ ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Ц.УРТНАСАН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Б.ГАНДӨЛ